# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1994 оны 10 сарын 17 өдөр | Дугаар А-185 | Улаанбаатар хот

Албадан эмчилгээний эмнэлэг
байгуулах тухай

1.Монгол улсын Засгийн газрын 1994 оны 175 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Сэтгэцийн өвчтөний хөдөлмөр эмчилгээний эмнэлэг"-ийг 75 ортой болгон өргөтгөх замаар Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх эмнэлэг болгон зохион байгуулж үйл ажиллагааг нь 1994 оны 10 дугаар сарын 20-ноос эхлүүлэн ажиллуулахыг Эрүүл мэндийн газар /Н.Буян-Өлзий/-д даалгасугай.

2.Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтанд ажиллах цагдаагийн хэсгийг шинээр зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн газар /Ч.Амарболд/-т, хөрөнгийг шийдэж өгөхийг Санхүүгийн хэлтэс /Н.Гонгор/-т даалгасугай.

3.Архинд донтох өвчтэй хүмүүсийг олж тогтоох, эмнэлгийн шинжилгээ хийлгэх, шүүхээс эмнэлэгт хүргэх үүрэгтэй цагдаагийн хөдөлгөөний хэсгийг энэ оны орон тоо, төсөвтөө багтаан байгуулж ажиллахыг Цагдаагийн газар /Н.Ч.Амарболд/-т үүрэг болгосугай.

4.Одоогийн эмнэлгийн шинэ зохион байгуулалттай холбогдуулж цахилгаан, сантехникийн засвар, цагдаагийн харуулын байр, цонх, хашааны хамгаалалтыг шинээр хийхэд шаардагдах хөрөнгийг гүйцэтгэлээр нь хянаж өгөхийг Санхүүгийн хэлтэс /Н.Гонгор/-т үүрэг болгосугай.

5.Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх эмнэлгийн цагдаагийн хэсгийн үйлчилгээнд зориулан 1-2 автомашин ажиллуулж түүнд шаардагдах хөрөнгийг шийдэж өгөхийг Санхүүгийн хэлтэс /Н.Гонгор/-т даалгасугай.

6.Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 1992 оны 136 тоот Сэтгэцийн өвчтөний хөдөлмөр эмчилгээний эмнэлэг байгуулах тухай тушаалыг хүчингүй болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.БААСАНЖАВ

Засаг захиргааны хэлтэс
Боловсруулсан
5% м Жөнгөнцэцэг
нийлсэн